

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд:

“ХХ.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2017 оны хагас жилийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:


1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажил үүргээ хангалтгүй биелүүлж, 2017 оны хагас жилийн үнэлгээний дүнгээр хангалтгүй гэж дүгнэгдсэн Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт хариуцлага тооцохыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад;

2. Яамныхаа хэмжээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайланг нэгтгэн ирүүлэх ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн яамны холбогдох албан тушаалтнуудад арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатарт;

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах ажлыг хангалтгүй биелүүлж, 2017 оны хагас жилийн үнэлгээний дүнгээр хангалтгүй гэж дүгнэгдсэн Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганболд, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Соёлчхүү, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Баянмөнх нарт хариуцлага тооцож ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт;

4. Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нь даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр тайлагнах, “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” /www.unelgee.gov.mn/-д байршуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт;

5. 2017 оны хагас жилийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа шийдвэрийг заалт тус бүрээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР